



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам
(САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх
өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ын дарга Б.Жагараас: “Монгол Улсын нэр бүхий иргэд бид Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан эвлэлдэн нэгдэх эрхийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдөр улс төрийн намыг үүсгэн байгуулах Их Хурал зарлан Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Намыг албан ёсоор үүсгэн байгуулсан бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 30 дугаар тогтоолын биелэлтийг хангаж, улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтээ дахин бичиг баримтын хамт хүргүүлж байгааг хүлээн авч, улсын бүртгэлд бүртгэж өгнө үү” гэжээ.

Тухайн намыг үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг 4 удаа шүүхэд ирүүлснийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 03, 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 14, 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 20, 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолуудаар хангахгүй орхиж, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан байна.

2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаартай Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ын үүсгэн байгуулах Их Хурлын Төлөөлөгчдийн тогтоолоор “... намын батлагдсан дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт”-ийг хавсралтаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр тус намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг тухайн намын дарга Б.Жагар гаргаж, 2 хавтас бүхий 1073 хуудас баримтыг хавсаргаж ирүүлснийг шүүх хүлээн авч, Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн

хуралдааны 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралт “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-д заасан шаардлага хангасан эсэхэд нягтлах ажиллагаа явуулсан.

Энэ хүрээнд, өргөдөлд хавсаргаж ирүүлсэн тухайн намын 867 гишүүний мэдээлэл нь Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна”; нам үүсгэн байгуулах Их Хурал нь мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна”; 9 дүгээр зүйлийн 9.3-т “Нам нь Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ.” гээд 9.3.7-д “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/,” гэж заасан шаардлагад нийцэж буй эсэхэд, түүнчлэн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 20, 30 дугаар тогтоолуудын үндэслэлд дурдсан зөрчлүүд арилсан эсэхийг шалгаж, улмаар Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2, 27.4.4-т зааснаар сонсох ажиллагааг явуулан тайлбарыг бичгээр, холбогдох баримтын хамт авсан болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ын дарга Б.Жагарын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гаргасан “тус намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” өргөдлийг дараах үндэслэлүүдээр хангахгүй орхиж, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг. Өргөдөл, түүнд хавсарган ирүүлсэн баримтаас үзэхэд, Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН) нь өмнөх 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан намын үүсгэн байгуулах Их Хурлын Төлөөлөгчдийн 07 дугаар тогтоолоор тухайн хурлаа “... Улсын дээд шүүхээс улсын бүртгэлд намыг бүртгэх хүртэлх хугацаанд нээлттэй үлдэх ...”-ээр шийдвэрлэсэн, улмаар 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн нам үүсгэн байгуулах хурлаа 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 12 цагт “Монголын Залуучуудын холбоо”-ны байрны 209 тоотод үргэлжлүүлэн хийхээр зар /зарлал/-ыг намынхаа фейсбүүк, цахим групп хуудас, дотоод чат болон утсаар гишүүд, төлөөлөгчдөдөө мэдэгдсэн; тухайн өдөр хурлыг хуралдуулж өмнөх Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 30 дугаар тогтоолын үндэслэл болсон “намын дүрэм нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан шаардлагыг хангаагүй, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 20 дугаар тогтоолд заасан зөрчлүүд бүрэн арилаагүй” гэсэн зөрчлийг арилгах үүднээс “... намын батлагдсан дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт”-ийг оруулан баталж, Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ын үүсгэн байгуулах Их Хурлын Төлөөлөгчдийн 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг гаргажээ.

Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид үүсгэн байгуулах хурал” гэх/-аар үүсгэн байгуулна” гээд 8.2-т “Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна”, 10 дугаар зүйлийн 10.1-д “Улсын дээд шүүх намыг дараахь үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана.” гээд 10.1.6-д “хуульд заасан бусад үндэслэл” гэж тус тус зааснаар нам үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулахад ямар нөхцөл

хангасан байхыг, үүний дотор хугацааны асуудлыг сонголтгүйгээр тодорхой, нарийвчлан зааж, энэхүү хуулиар үүрэг болгосон заалтыг илтэд зөрчсөн тохиолдолд хууль тогтоогчоос “хуульд заасан бусад үндэслэл”-д хамааруулан бүртгэхээс татгалзахыг тусгайлан зохицуулсан байна.

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ны даргаас “2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн нам үүсгэн байгуулах Их Хурлыг нээлттэй үлдээсэн учраас 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр үргэлжлүүлэн хуралдсан” гэх тайлбарыг ирүүлж байгаа боловч нам шинээр үүсгэн байгуулагдаж байгаа тохиолдолд Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан зохицуулалтыг мөрдөж хэрэгжүүлэх, тухайлбал “2 сарын өмнө” гэж заасан хугацаанд тухайн намын үүсгэн байгуулах хурал зарлагдаж, тухайн хугацааны шаардлагыг хангаж хуралдсан хурлаар намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг баталсан байх шаардлагатай.

Нөгөөтэйгүүр, хурлыг нээлттэй үлдээх болон намын батлагдсан дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийн асуудал нь “нам үүсгэн байгуулагдсаныг улсын бүртгэлд бүртгэсэн” тохиолдолд буюу бүртгэсний дараа хийгдэх ажиллагаа бөгөөд нэгэнт нам улсын бүртгэлд бүртгэгдээгүй, өөрөөр хэлбэл, улсын бүртгэлийн гэрчилгээ байхгүй, намын дүрэм Улсын дээд шүүхэд хянагдаж албан ёсоор хүчин төгөлдөр болоогүй байхад дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж батлах хүртэл хурлыг нээлттэй үлдэх асуудал байх боломжгүй юм.

Иймд, Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ын үүсгэн байгуулах Их Хурлыг өмнөх Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол гарсан өдрөөс хойш 25 хоногт буюу 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хуралдуулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасантай нийцээгүй гэж үзэх үндэслэлтэй.

Хоёр. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа этгээд нь бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө” гэж улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргагчийн үүргийг тодорхойлж, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т “гишүүдийн тоо нь энэ хуулийн 9.3.7-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн” тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзахаар заасан.

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-аас 867 иргэний мэдээллийг файлаар болон гарын үсэг бүхий гар бүртгэлийг иргэний үнэмлэхийн хамт ирүүлсэн; шүүхээс нягтлан шалгах үүргийнхээ хүрээнд эдгээр иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбарыг өмнөх Улсын бүртгэлийн ерөнхий газрын лавлагаа болон гар, цахим бүртгэлтэй нэг бүрчлэн харьцуулан тулгаснаас гадна тохиолдлын журмаар түүвэрлэн 343 иргэний мэдээллийг нягтлан шалгахад: тухайн намын гишүүн биш гэх 19, давхар намын харьяалалтай гэх 7, сонгуулийн эрх бүхий 18 насанд хүрээгүй 2, холбогдох утсан дээр байхгүй 18 иргэн байхаас гадна гишүүдийн гар бүртгэл, файлын бүртгэл нь хоорондоо зөрүүтэй, зарим иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбар байхгүй, дутуу, мэдээлэл уншигдахгүй бүдэг, ургийн овог, нэр, алдаатай, хаягийн мэдээлэл нь иргэний үнэмлэхийн хуулбараас зөрүүтэй гэх мэт зөрчлүүд илэрсэн тул Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7-д заасан шаардлагыг хангаагүй, бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх үүргээ хангалттай биелүүлээгүй буюу баримтын бүрдэл дутуу гэж үзэх үндэслэлтэй.

Үүнээс гадна зарим иргэдийн утасны дугаар ашиглалтад байхгүй, орох ярианы эрх хаагдсан байх тул шүүхэд ирүүлж байгаа баримтдаа гишүүдийнхээ үнэн зөв мэдээллийг ирүүлэхийг дурдах нь зүйтэй.

Иймээс Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ыг “нам үүсгэн байгуулах Их Хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй”, “801-ээс доошгүй гишүүнтэй байх” хуулийн шаардлагыг зөрчсөн гэсэн үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж, өргөдөл, түүнд хавсаргасан баримтыг буцаахаар тогтов.

Дурдсан зөрчлийг арилгаж, Монгол Улсын Үндсэн хууль, Улсын төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд нийцүүлэн нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэх өргөдлөө дахин гаргахад энэхүү тогтоол саад болохгүйг тэмдэглэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр зүйлийн 9.3.7, 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.3-т заасныг баримтлан Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2. Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ
М.БАТСУУРЬ